



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2007 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ/Рашаан сувилалд эмчилж сувилах өвчний жагсаалт/

Эрүүл мэндийн тухай хуулийн 38.1 дүгээр зүйл, Рашааны тухай хууль, Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж рашаан сувиллын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

- 1.Рашаан сувилалд эмчилж сувилах өвчний жагсаалтыг нэгдүгээр, Рашаан сувилалд эмчилгээ сувилгаа үзүүлэх журмыг хоёрдугаар, илгээх картны загварыг гуравдугаар хавсралт ёсоор баталсугай.
- 2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийг удирдах газар (Л.Жамбалжав), Мэдээлэл хяналт шинжилгээ үнэлгээний газар (О.Баяр) нарт даалгасугай.
- 3.Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг нийт рашаан сувилал, эрүүл мэндийн байгууллагын удирдлага, иргэдэд үүрэг болгосугай.
- 4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 1990 оны А/09, 1991 оны А/179 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Д. ТУЯА

Улсын бүртгэлийн 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2804 дүгээрт бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2012-07-06 ӨДРИЙН 247 ДУГААР ТУШААЛААР ХҮЧИНГҮЙ БОЛГСОН.